



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Г “Эрдэнэт хүнс” ХК-ийн бусад 7  
хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах  
саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, “Чингис хаан инженеринг групп” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт хүнс” ХК-ийн нийт хувьцааны 36.79 хувь буюу 145,075 ширхэг хувьцааг эзэмшигч “Чингис хаан инженеринг групп” ХХК/Б.Ганбаатар/-д тус компанийн үлдэх 63.21 хувь буюу 249,223 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,184 /нэг мянга нэг зуун наян дөрвөн/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авч компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эзэмшихээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч, худалдан авах саналын хүчинтэй байх хугацааг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг “Чингис хаан инженеринг групп” ХХК/Б.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгийн газар/Д.Нямцэрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН